

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: [dalaivandarkhan@gmail.com](mailto:dalaivandarkhan@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	12
3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	13
4. Аудитын тайлан .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Дотоод хяналт.....	15
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
4.4. Материаллаг байдал .....	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
8. Аудитын илрүүлэлт .....	17
8.2 Зөвлөмж .....	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20



“СЭЛЭНГЭ АЗЗА” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ М. БАТБОЛД ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II бар  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА 2022/01-НА-СТА-ТӨА

тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч-байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	135,886,851.30	63,311,279.09
1.1.2	Дансны авлага	616,862,721.96	1,194,545,089.63
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	9,966,536.81
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	170,555,315.87	192,067,495.04
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	543,161,760.00	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	1,466,466,649.13	1,459,890,400.57
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	715,011,888.97	607,692,507.77
1.2.2	Биет бус хөрөнгө	304,942,336.00	303,438,903.00
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	1,019,954,224.97	911,131,410.77
1.3	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	2,486,420,874.10	2,371,021,811.34
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.1.1	Дансны өглөг	285,491,244.46	268,895,740.56
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	5,251,163.52	91,503,992.06
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	58,899,537.19	18,342,466.62
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	12,858,059.16	9,737,632.08
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	362,500,004.33	388,479,831.32
2.1.2	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	325,147,885.00	325,147,885.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	325,147,885.00	325,147,885.00
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	687,647,889.33	713,627,716.32
	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
2.3	<b>Өмч</b>	507,379,700.00	507,379,700.00
2.3.1	-төрийн	507,379,700.00	507,379,700.00
2.3.2	-хувийн	-	-
2.3.3	-хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	336,173,513.05	336,173,513.05
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	302,542,000.00	302,542,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	652,677,771.72	511,298,881.97
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	1,798,772,984.77	1,657,394,095.02
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	2,486,420,874.10	2,371,021,811.34

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	Үзүүлэлт	эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,731,690,620.39	1,698,397,623.92
2	Борлуулалтын өртөг	1,378,276,660.79	1,513,516,122.21
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	353,413,959.60	184,881,501.71
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	1,581,905.90	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	12,657,837.83	67,570,756.67
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(295,891,746.01)	207,811,306.49
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	(19,722,797.14)	35,687,320.96
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	52,039,160.18	8,953,630.93
19	Орлогын татварын зардал	5,203,916.01	895,363.09
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	46,835,244.17	8,058,267.84
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	46,835,244.17	8,058,267.84
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>	46,835,244.17	8,058,267.84
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	/төгрөгөөр/	
					Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	507,379,700.00	336,173,513.05	302,542,000.00	652,677,771.72	1,798,772,984.77
2	Залруулсан үлдэгдэл	507,379,700.00	336,173,513.05	302,542,000.00	652,677,771.72	1,798,772,984.77
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	507,379,700.00	336,173,513.05	302,542,000.00	652,677,771.72	1,798,772,984.77
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(149,437,157.59)	(149,437,157.59)
2	Залруулсан үлдэгдэл	507,379,700.00	336,173,513.05	302,542,000.00	503,240,614.13	1,649,335,827.18
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	8,058,267.84	8,058,267.84
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	507,379,700.00	336,173,513.05	302,542,000.00	511,298,881.97	1,657,394,095.02

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
1.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	1,679,392,164.39	1,077,221,051.59
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	48,748,160.00	185,943,973.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,449,379,159.00	786,906,667.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	181,264,845.39	104,370,411.59
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	1,607,284,811.41	1,145,963,433.80
1.2.1	Ажиллагчдад төлсөн	464,876,508.50	380,626,323.48
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	151,676,747.91	130,615,385.94
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	183,810,839.47	88,837,976.90
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	43,461,178.00	23,742,674.84
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	318,986,334.00	285,867,730.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	6,773,511.07	7,358,929.45
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	246,958,363.05	114,971,889.19
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		4,824,624.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	197,514,840.48	109,117,900.00
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	72,107,352.98	(68,742,382.21)
2	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
2.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
3	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
3.1	<b>Мөнгөн орлогын дүн</b>	80,000,000.00	
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	80,000,000.00	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-

3.2	Мөнгөн зарлагын дүн	65,182,397.18	3,833,190.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	63,032,397.18	
3.2.4	Төлсөн ногдол ашиг	2,150,000.00	3,833,190.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	14,817,602.82	(3,833,190.00)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	86,924,955.80	72,575,572.21
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	48,961,895.50	135,886,851.30
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	135,886,851.30	63,311,279.09

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмж их нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хув ь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт	төгрөг	1,745,930,400.00	1,850,000,000.0	1,765,968,380.59	84,031,617.41	0.45
	а/Улсын чанартай авто замын засвар арчлалт	төгрөг	714,350,200.00	800,000,000.00	491,854,893.54	308,145,106.46)	38.5
	б/Орон нутгийн чанартай замын засвар арчлалт, бусад	төгрөг	940,696,900.00	1,050,000,000.00	1,148,195,732.70	(98,195,732.7)	-
	Бүтээгдэхүүн борлуулалт	төгрөг	76,643,600.00	-	58,346,997.68	(58,346,997.68	
	<b>Бусад орлого</b>	төгрөг	14,239,700.00	-	67,570,756.67	67,570,756.67	7.33
2	<b>Нийт орлого</b>	төгрөг	<b>1,745,930,400.00</b>	<b>1,850,000,000.00</b>	<b>1,765,968,380.59</b>	84,031,617.41	
3	<b>Нийт зардал</b>	төгрөг	<b>1,693,891,200.00</b>	<b>1,786,031,500.00</b>	<b>1,757,014,749.66</b>	29,016,300.34	0.68
	<b>Үүнээс: Удирдлагын зардал</b>	төгрөг	<b>295,897,700.00</b>	<b>270,530,500.00</b>	<b>207,811,306.49</b>	62,719,193.51	0.70
4	Татварын өмнөх ашиг	төгрөг	52,039,200.00	63,968,500.00	8,953,630.93	55,014,869.07	0.17
5	Цэвэр ашиг /алдагдал /	төгрөг	46,835,300.00	57,571,700.00	8,058,267.84	49,513,432.16	0.17
6	Төсвийн төлбөр	төгрөг	396,900,700.00	330,703,500.00	241,139,372.02	89,564,127.98	0.29
	а/Орлогын татвар	төгрөг	5,203,900.00		895,363.09	(895,363.09)	0.17
	б/НӨАТ	төгрөг	181,878,500.00		98,355,640.22	(98,355,640.22 )	-
	в/НДШ	төгрөг	149,757,800.00		130,615,385.94	(130,615,385.94)	0.87
	г/ХАОАТ	төгрөг	38,149,600.00		8,063,000.82	(8,063,000.82 )	-
	д/ҮХЭХАТ	төгрөг	3,240,000.00		1,729,485.95	(1,729,485.95)	-
	ё/АТБӨЯХАТ	төгрөг	12,343,000.00		1,245,446.00	(1,245,446.00)	-
	ж/Бусад татвар	төгрөг	4,178,000.00		235,000.50	(235,000.50 )	-
	Төрийн өмчийн ноогдол ашиг	төгрөг	2,150,000.00	2,543,000.00	3,833,190.00	(1,290,190.00)	1.78
7	Нийт ажиллагсдын тоо	хүн	50.00	60.00	51.00	9.00	1.02
8	Нийт цалингийн сан	төгрөг	586,608,200.00	454,680,000.00	380,626,323.48	74,053,676.52	0.65
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг	977,700.00	631,500.00	621,938.44	9,561.56	0.64
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	төгрөг	0.9702	0.9654	0.9949	0.0295	-
11	Хөрөнгө оруулалт	төгрөг	40,529,400.00	44,440,000.00	3,999,818.18	40,710,451.82	-
12	Нийт авлага	төгрөг	616,862,700.00	110,000,000.00	1,194,545,089.63	(1,084,545,089.63)	1.94
	Үүнээс: найдваргүй	төгрөг	1,651,200.00			-	-
13	Нийт өглөг	төгрөг	687,647,900.00	475,147,900.00	713,627,716.32	(238,479,816.32)	1.04
	Богино хугацаат өглөг	төгрөг	362,500,000.00	150,000,000.00	388,479,831.32	(238,479,831.32)	1.07
	Урт хугацаат өглөг	төгрөг	325,147,900.00	325,147,900.00	325,147,885.00	15.00	1.00

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь "Олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам, төмөр бетон гүүр хоолойн засвар арчлалтын ажлыг хариуцан авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг байнга ханган ажиллахыг эрхэмлэх" гэсэн зорилт тавин ажиллаж байна.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Зам барилга, засвар арчлалт,
- Гадаад дотоод худалдаа,,
- Асфальт бетон үйлдвэрлэл
- Авто замын тээвэр,
- Механизмын үйлчилгээ.

Тус компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд "хувьцаат компани" гэж бүртгэсэн бөгөөд өмчийн 100 хувийг төр эзэмшдэг төрийн өмчит хувьцаат компани юм.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь Засгийн газрын 2006 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 173 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..." гэсэн заалттай нийцэж байна.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг нийт 45,391.5 мянган төгрөгөөр, гишүүдийн сарын цалинг 162.0-350.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 05 дугаар тогтоолоор аудит, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороодын дарга, гишүүдийг шинэчлэн баталж төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 5, хараат бус 6, нийт 11 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2021 онд 6 удаа зохион байгуулж%, компанийн 2019-2021 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах, аудитаар гарсан зөрчлийг арилгаж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, компанийн гүйцэтгэх захирлыг томилон, 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот

түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой, / Зам тээврийн яамнаас олгодог зам засвар, арчлалтын санхүүжилттэй холбогдох /
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 115,399.0 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	135,886.8	63,311.3	(72,575.5)
Авлага	580,850.0	1,204,511.6	623,661.6
Татвар, НДШ-ийн авлага	36,012.7		(36,012.7)
Бараа материал	170,555.3	192,067.5	21,512.2
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	543,161.8		(543,161.8)
Үндсэн хөрөнгө	1,019,954.2	911,131.4	(108,822.8)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,486,420.8</b>	<b>2,371,021.8</b>	<b>(115,399.0)</b>
Өр төлбөр	687,647.8	713,627.7	25,979.9
Эздийн өмч	1,798,773.0	1,657,394.1	(141,378.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,486,420.8</b>	<b>2,371,021.8</b>	<b>(115,399.0)</b>

--	--	--	--

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 72,575.5 мянган төгрөгөөр буурсан нь 1,161,969.0 мянган төгрөгийн орлого олж, 1,234,547.6 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 1,204,511.6 мянган төгрөг болж 623,661.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Улаанбаатар-Дархан чиглэлийн CW-4 дугаар хэсгийн түр замын туслан гүйцэтгэгчийн ажлын хөлсний санхүүжилт орж ирээгүйгээс голлон шалтгаалжээ.

Урьдчилж гарсан зардал оны эхэнд 543,161.8 мянган төгрөг байсан бол оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан нь Улаанбаатар-Дархан чиглэлийн CW-4 дугаар хэсгийн түр замын ажлын орлого, зарлагыг тайлант онд хүлээн зөвшөөрч бүртгэснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 192,067.5 мянган төгрөг болж 21,512.2 төгрөгөөр нэмэгдсэн нь 466,259.6 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 444,747.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,999.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ТУЗ-өөс баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 3,999.8 мянган төгрөгийн компьютер худалдан авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 713,627.7 мянган төгрөг болж 25,979.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Тавхан Уул ХХК-д өгөх 14,799.6 мянган төгрөгийн, хувь хүмүүст өгөх 2,866.4 мянган төгрөгийн, Төрийн банкны богино хугацаат зээлийн 40,557.0 мянган төгрөгийн, ҮЭХ-ны 3,120.4 мянган төгрөгийн зэрэг өр төлбөрүүдийг барагдуулж, 2017-2020 онд үүссэн НӨАТ-ын өр төлбөрийн 149,437.2 мянган төгрөгийг данс бүртгэлд тусгаснаас голлон шалтгаалжээ.

Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг 511,298.8 мянган төгрөг болж 141,378.9 мянган төгрөгөөр буурсан нь 2017-2020 оны татварын өр төлбөрийг төрийн өмчийн бүртгэл рүү залруулагдсан 149,437.1 мянган төгрөгөөр хасагдуулж, өмнөх оны хуримтлагдсан ашиг 8,058.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 615 дугаар тогтоолоор "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд тайлант оны нийт орлогыг 1,850,000.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,786,031.5 мянган

төгрөгөөр, ашгийг 63,968.5 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 4 арга хэмжээнд 44,440.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,765,968.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,757,014.7 мянган төгрөгийн зардал гарган, 8,953.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

2021 онд Зам тээврийн яамнаас улсын болон орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажилд 491,854.9 мянган төгрөгийн, Улаанбаатар-Дархан чиглэлийн түр замын туслан гүйцэтгэгчийн ажлын хөлс 881,950.0 мянган төгрөгийн, аймаг орон нутгаас гүйцэтгүүлсэн төсөл арга хэмжээний ажлын хөлс 253,960.9 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 138,202.6 мянган төгрөгийн зэрэг нийт 1,765,968.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Нийт орлогын гүйцэтгэл 1,765,968.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 84,031.8 төгрөг буюу 4.8 хувиар тасарсан нь Улаанбаатар Дархан чиглэлийн авто зам засварын ажил хийгдэж байгаагаас зам засвар арчлалтын санхүүжилт буурсан, тайлант онд татварын өр төлбөрөөс шалтгаалан тендерт орох боломжгүй байсан зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,757,014.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 29,016.8 төгрөг буюу 1.6 хувиар дутуу байгаа нь зам засварын ажлын төлөвлөгөө тасарсантай холбоотойгоор зардал буурснаас шалтгаалсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 8,953.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 55,014.8 мянган төгрөгөөр бага байгаа нь нийт орлогын төлөвлөгөө 4.8 хувиар дутуу биелсэн, зардал 1.6 хувиар хэмнэгдсэнээс тус тус шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 1124 дугаар тогтоолын дагуу тайлант оны ногдол ашиг болох 3,833.2 мянган төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

#### 4. Аудитын тайлан

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК-ийн /цаашид "Сэлэнгэ АЗЗА" ТӨХК гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн татвар, нийгмийн даатгалын өр төлбөртэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Б.Сувд-Эрдэнэ, Ж.Сайнбилэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

"Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь 2021 оны санхүүгийн тайланг "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК-ийн Дархан салбарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Дотоод хяналт**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

#### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ АЗЗА" ТӨХК нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **4.4. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,757,014.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,570.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12,299.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Сэлэнгэ АЗЗА ТӨХК нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс бүх мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3-д "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасны дагуу цалин хөлсийг нэмэгдүүлээгүй шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

Харин төсөв зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэн тогтоож, батлаагүй байна.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 14,951.1 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 2 зөвлөмжийн 1-ийг хэрэгжүүлсэн байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	1	14,951.1	1	14,951.1	100.0
Зөвлөмж	2	928.6	1	928.6	50.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>15,879.7</b>	<b>2</b>	<b>15,879.7</b>	<b>75.0</b>

Өмнөх аудитаар өгсөн санхүү, нягтлан бодох бүртгэлийн программыг холбогдох хууль стандартад нийцүүлэн шинэчлэх, бүртгэл тооцоонд ашиглах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 2005 оноос ашиглаж байгаа Пирамид 4.0 программаар санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгэгдээгүй, татвар, нийгмийн даатгалын системтэй холбогдох боломжгүй бөгөөд цалингийн программ байхгүй байгаа тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

7.1 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь "0" үлдэгдэлтэй болсон 587,538.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 69 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа тул УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө"-ийн 49 дэх "... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэсэн заалтын дагуу "0" үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

#### 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 62,710.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 11,341.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 51,369.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй **11,341.8** мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон **17,570.1** мянган төгрөгийн түвшнээс **6,228.3** мянган төгрөгөөр бага байгаа тул "Зөрчилгүй" дүгнэлт өглөө.

##### 8.1 Албан шаардлага

1. Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн 1435, 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 1506 дугаар шийдвэрээр хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон 2

ажилтанд ажилгүй байсан хугацааны нийт 11,341.8 мянган төгрөгийн цалин хөлсийг байгууллагаас барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь "Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна", Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй." гэсэн заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хохирлыг нөхөн төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэх.

## 8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Дансны авлагатай холбоотой асуудал

1.1.1 **Илрүүлэлт:** Өмнөх онд жолооч Н.Шинэбаярт илүү олгосон 1,200.0 мянган төгрөгийн тээврийн хөлсийг авлага үүсгэж, бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1.2 **Өгсөн зөвлөмж:** Өглөг авлагын тооцоог дахин хянан, 2022 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд залруулга хийж, барагдуулах.

### 2. Цалин хөлстэй холбоотой асуудал

1.2.1 **Илрүүлэлт:** Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 2 ажилтны цалинг 664.3 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, хуульчид олгосон 5,040.0 мянган төгрөгийн цалинг тайлагнаагүйгээс НДШ-ийн авлага, өр төлбөр үүсэх эрсдэл үүссэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.1 дэх "Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2.2 **Өгсөн зөвлөмж:** 2022 оны эхний хагас жилийн тайланд НДШ-ийн авлага, өр төлбөрийг хянаж, тооцоо нийлэх, авлага, өр төлбөрийг барагдуулах, холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг мөрдөж ажиллах.

4317143398  
УФОА00055 0100400

### 3. Татварын өр төлбөртэй холбоотой асуудал

1.2.1 **Илрүүлэлт:** Татварын тооцооллыг үнэн зөв хийж, баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд 29,217.7 мянган төгрөгийн НӨАТ-ын өр төлбөрийг дутуу тайлагнасан, хүү торгуулийн зардлын 2,705.3 мянган төгрөг, шүүхийн шийдвэрээр олгосон ажлын хөлс 12,541.8 мянган төгрөг зэрэг нийт 15,247.1 мянган төгрөгийн зардлыг татвар ногдох орлогоос хасаж тайлагнан, татварын өр төлбөр үүсэж болзошгүй эрсдэлийг үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "... тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2.2 **Өгсөн зөвлөмж:** Татварын тооцоог дахин хянаж, тооцоо нийлэн 2022 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд залруулж бүртгэх, цаашид холбогдох хууль, заавар, журмыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
				/мянган төгрөгөөр/											
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	СЭА-2022/01-НА-СТА-ТӨА	Шүүхийн шийдвэрээр 2 ажилтанд цалин олгосон	1	11,341.8					1	11,341.8				
2	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	СЭА-2022/01-НА-СТА-ТӨА	Өмнөх оны зөвлөмж биелүүлээгүй	1						1					
3	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	СЭА-2022/01-НА-СТА-ТӨА	Тооцоо нийлж, авлага үүсгээгүй	1	1,200.0									1	1,200.0
4	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	СЭА-2022/01-НА-СТА-ТӨА	Татварын тооцооллыг үнэн зөв хийж, тайлагнаагүй.	1	44,464.8									1	44,464.8
5	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	СЭА-2022/01-НА-СТА-ТӨА	НДШ-ийн тооцооллыг үнэн зөв хийж, баталгаажуулаагүй	1	5,704.3									1	5,704.3
<b>ДҮН</b>				<b>5</b>	<b>62,710.9</b>					<b>2</b>	<b>11,341.8</b>			<b>3</b>	<b>51,369.1</b>
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1															
<b>ДҮН</b>															
<b>НИЙТ ДҮН</b>															